

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 10 дүгээр сарын 01

Дугаар

37-074/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо, Хүүхэд залуучуудын театрын барилгын гадна талбайн тохижилтын ажлыг Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамж шийдвэрээр байгуулагдсан 7 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийн гадна талбайн тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комисс 2025 оны 8 сарын 22-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн гадна тохижилтын ажил, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо, дугаар: 215/2020

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: Г.Л.П-А3-06/2019, СП-А3310/24

2.3. Захиалагч: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9069001078, регистрийн дугаар: 6594204, хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, Денверийн гудамж, Дипломат байгууллагын үйлчилгээ эрхлэх газар ТӨҮГ-ын 15 байр, холбоо барих утас: 51265626, цахим хаяг: info@mos.gov.mn

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9013001019, регистрийн дугаар: 5164753, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Их тойруу Барилгын хөгжлийн төвийн байр, холбоо барих утас: 70122244, цахим хаяг: info@barilga.gov.mn

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Содон номин констракшн ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011380115, регистрийн дугаар: 5658063, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ12-37/22, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26 дугаар хороо, Баянмонгол 416-172 тоот, холбоо барих утас: 99113051, 70539999, цахим хаяг: sodonnomin@gmail.com

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй

2.6. Гадна талбайн тохижилтын зураг төсөл зохиогч байгууллага: Стийл проект ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011642016, регистрийн дугаар: 6122973, зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар: 3118-638/22, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, Релид хөрөн 7 байр, 87 тоот, холбоо барих утас: 88103792, цахим хаяг: steelproect@gmail.com

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР**

Барилга байгууламжийн их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комисс

2.7. Барилга байгууламжийн гадна талбайн тохижилтын ашиглагч, өмчлөгч байгууллага: Хүүхэд залуучуудын театр, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9069001192, регистрийн дугаар: 6856187, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо, 33-34 тоот, холбоо барих утас: 99113728, цахим хаяг: info@youththeatre.mn

ХЯНАЛТ ШААРДАЛТЫН
ГАЗАР
Барилга байгууламжийн их засаг
шинэчлэлтийн ажлыг ашиглалт
орлуулах комисс

2.8. Барилга байгууламжийн гадна талбайн тохижилтын төлөв байдал.
Шаардлага хангасан

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангасан тул

3.1. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай, БСШУЯ/202001206 тоот гэрээний дугаартай, Соёлын ордны гадна тохижилтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/ түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэхүү гадна тохижилтын ажил нь зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийн гадна тохижилтын ажлыг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) Барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагуудад 14 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

- б) Барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) Барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 3 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн 12 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Сонгинохайрхан дүүргийн 5 дугаар хороо, Хүүхэд залуучуудын театрын гадна талбайн тохижилтын ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай
Хүүхэд залуучуудын театрын тохижилтын ажил
/Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)


Нарийн бичиг:
Содон номин констракшн ХХК-ийн
захирал



(Б.Баттулга)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын
үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

---o0o---



СОЁЛЫН ОРДНЫ ГАДНА ТОХИЖИЛТ
/УЛААНБААТАР, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ, 5 ДУГААР ХОРОО/-ЫН АЖЛЫГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай, БСШУЯ/202001206 тоот гэрээний дугаартай, Соёлын ордны гадна тохижилтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/ ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

Хуралд:

1. Комиссын дарга:

Хяналт шалгалтын газрын
барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

А.Мөнгөн

2. Комиссын нарийн бичгийн дарга:

Содон номин констракшн ХХК-ийн менежер

Ч.Золжаргал

Комиссын гишүүд:

3. Үндэсний төв архивын зураг төслийн баримтын
архивч

Б.Оюунжаргал

4. Ашиглагч байгууллага:

Хүүхэд, залуучуудын театрын захирал

Н.Ариунболд

5. Захиалагч байгууллага:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
хөрөнгө оруулалтын хэлтсийн хяналтын инженер

Б.Ган-Эрдэнэ

6. Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн
захиалагчийн хяналтын хэлтсийн хяналтын инженер

Э.Пүрэвжаргал

7. Зураг төсөл зохиогч байгууллага:

Стилл проект ХХК-ийн архитектор

Г.Эрдэнээ

ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 7
- Хүрэлцэн ирсэн – 7
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 7

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай, БСШУЯ/202001206 тоот гэрээний дугаартай, Соёлын ордны гадна тохижилтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/ ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд гадна тохижилтын ажлын зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Гүйцэтгэгч байгууллага:

Содон номин констракшн ХХК-ийн төслийн менежер **Ч.Золжаргал**

- Үүрэг даалгаварын биелэлтээр улсын комисст хүлээн авах, ашиглалтанд оруулах, ашиглалтанд их засвар шинэчлэлтийн ажлыг ашиглалта оруулах комисс

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууллагын их засвар
шинэчлэлтийн ажлыг ашиглалта
орлуулах комисс

Зураг төсөл зохиогч байгууллага:

Стиль проект ХХК-ийн архитектор **Г.Эрдэнээ**

- Соёлын ордны барилгын гадна тохижилтын ажилтай танилцлаа. Барилгын зүүн талын хэсэг газарт усны машин орсноос үүдэн хавтан тэгш байдлаа алдан хонхойсон байна. Үүнийг гүйцэтгэгч болон ашиглагч байгууллагын хоорондын хэлцлээр засварлахаар болов,
- Скүтерийн талбайг буулгаж оронд нь гулсуур болон бусад төлөвлөлтийг хийсэн, Зохиогчийн зүгээс тус ажлуудыг ашиглалтанд авах саналтай байна. Мөн ашиглагч байгууллагын хэлснээр гүйцээх болон засварлах шаардлагатай ажлуудыг гүйцээж, байнгын ашиглалтанд авахад татгалзах зүйлгүй.

Ашиглагч байгууллага:

Хүүхэд, залуучуудын театрын захирал **Н.Ариунболд**

- Гадна талбайн суулт ус тогтсон /төв талбай/ тэгшилж өгөх,
- Гадна гэрэлтүүлэг буюу том гэрэл /прожектор/ суулгаж өгөх,
- Усан оргилуурын усны шахалтыг нэмэгдүүлж өгөх,
- Гадна гэрэл 270 ширхэг байх ёстой тоо хэмжээ нийлэх, үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Үндэсний төв архивын зураг төслийн баримтын архивч **Б.Оюунжаргал**

- Тохижилтын ажлын хувийн хэрэгт ажил гүйцэтгэх гэрээний сунгалт бүрэн хийх, ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөн, зөвшилцсөн ажлуудын холбогдох баримтыг бүрэн хийж дотоод товьёг хийж өгөх,
- Ажлын болон гүйцэтгэлийн зургийг бүрэн бүрдэлтэй эх хувиар өгөх, ашиглагчтай ажил хүлээлцсэн акт хувийн хэрэгт хийх,
- Тохижилтын ажлын ил далд ажлын акт, гэрэл зургийг бүрэн бүрдэлтэй дотоод товьёг хийж өгөх,
- Тохижилтын ажилд хэрэглэсэн бараа материалын сертификат чанар, гарал үүслийн гэрчилгээг материал тус бүрээр бүрэн бүрдүүлж дотоод товьёг хийж өгөх,
- Зохиогчийн дүгнэлт шинэчлэгдсэн хувийн хэрэгт хийх. Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтийг үндэслэн байнгын ашиглалтад оруулах саналтай байна

Захиалагч байгууллага:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хөрөнгө оруулалтын хэлтсийн хяналтын инженер **Б.Ган-Эрдэнэ**

- Гадна зам талбайн хонхойсон болон эвдэрсэн хэсгийг засан сайжруулах. Зураг төслөөс өөрчлөгдсөн ажлын гүйцэтгэлийг зургаар баталгаажуулж өгөх. Үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ашиглалтад оруулах саналтай байна

Комиссын дарга:

Хяналт шалгалтын газрын барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**

- Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх заалтын дагуу захиалагч нь ажил гүйцэтгэх гэрээ, барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний хугацаа дууссан байх асуудалд тайлбар ирүүлэх,
- Зураг төсөвт тусгагдсан 25-06-11 үндэслэлийн дагуу ажлыг засан сайжруулах /зөөлөн асфельтаар хийх/,
- Гадна гэрэлтүүлэг болон бусад ажлыг захиалагчийг байлцуулан тооллого хийж актаар хүлээлцэж баталгаажуулан тоо хэмжээгээр гүйцэтгэлийн төсөв тоо хэмжээг гаргах,
- Гадна чулуун талбайг шинэчлэн засварлах. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай, БСШУЯ/202001206 тоот гэрээний дугаартай, Соёлын ордны гадна тохижилтын ажил /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 5 дугаар хороо/ ажлыг комиссын гишүүдийн гаргасан саналаар үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан.

Комиссын дарга:

Хяналт, шалгалтын газрын барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн.

Комиссын нарийн бичгийн дарга:

Содон номин констракшн ХХК-ийн захирал



(Б.Баттулга)